

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Хариултын хуудасны заавартай сайтар танилцана уу.

- 1. Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.**
- 2. Асуулт даалгавар бүрийг дуустал уншиж ойлгоорой.**
- 3. 1-15 сорилыг эхийн утга санаатай холбож ажиллаарай.**
- 4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.**

(Даалгавар бүр 2 оноотой)

УРТЫН ГОЛ МИНЬ ЗҮҮДНЭЭСЭЭ СЭРЖ БАЙНА

Цэв цэнхэр тэнгэр өнгө зүсээ Уртын голын минь мөсөн хучлагад шингээсэн юм уу, миний Уртын гол өвөлжингөө цэнхэртэн болортож, болортон цэнхэртэнэ. Үдшийн сар л тасхийн ойчиж, цочихдоо буцаад л тэнгэртээ дүүлэн гэрэлтэнэ. Харин Уртын гол минь юу ч болоогүй юм шиг зүүдлэн нойрсоно. Зүүдэндээ урьд эртийн явдлаа нэгд нэгэнгүй өнгөтөөр, өнгөт өнгөтдөө бүр солонгын долоон өнгөөр үзэн баясах нь бий.

Тэр цагт Уртын гол урсгал арвин болоод аян замын холд товолзонхон долгилсоор Хөх бүрдийн нуурт цутганхан хүрдэг байжухуй. Овоо толгойн хаяагаар шуугин өнгөрч, Талын улааны бэлээр шуударч, ай сав болох Хөх бүрдийн нууртаа, ээждээ тэмүүлсэн хүүхэд шиг шулганан очиж, нийлдэг байв л... Бороо хуртай үед хүн амьтны хөл хорьж, хэд хоногоор саатуулан үерлэх нь ч энүүхэнд сэн... Эрэг хөвөөгөөр нь айл хотол зусаж найрлан, айраг цагаа дэлгэрч, адуу мал цуван, хүн зоны магнай тэнийж, хүүхэд багачуудын хөөрцөглөн тоглохыг угсал мандалдаа хэчнээн удаа тольдсон гэх вэ?

Өвөлдөө цэнхэр, номин ногоон, цасан цагаан өнгөөр мөстдөг бол хавартаа шаргалтан боргиотож, зундаа гүн хөх өнгөөр хөөсрөн давлагаалж, намартаа удвал цэцгийн өнгөөр туналзан цэлэлзэнэ. Чухам л солонгын долоон өнгөөр эгшиглэн урсдаг сан... Уртын гол ийнхүү эртийн явдлаа зүүдлэнхэн сэрж байна. Мөсөн доор нь жирвэлзэн сэрэх урсгал мөнгөн утас шиг гялбалзан тодорч, хүүхдийн бойтгийн хонх шиг жингэнэн хоржигноно. Ёроолын чулууд нь өнгө бүрээр гэрэлтэн тодрох билээ. Мөсөн хучлага нь захаасаа сэмэрч, хэрээс, хэгдэс үүсэж, элдэв төрлийн хээ хуарыг урлах ажгуу. Тун удахгүй л хаврын дуугаа дууланхан, мэлтэлзэнхэн мэлмэрнэ дээ. Жил бүр ирж зусдаг хоёр улаан ангир нь санан ганганасаар нэг л өглөө жигүүр амраан мандалд нь буудаг билээ.

Уртын гол эрт цагийн явдлаа зүүдэндээ нэг бүрчлэн үзэн баясдаг ч сэрээд уй гунигт автанхан бүүдийх нь он онд. Урсгал нь саарч, аян холын зам нь богиносож, эрэг хөвөөгөөр нь зусах айл хотол цөөрсөн нь юуны учир юм бол? Одоо яаж ч хөвөлзөөд Овоо толгой өнгөрч урсахаасаа нэгэнт больсон бөгөөд хаа нэг жил, бороо элбэгтэй зунд бол Дунд булагийн устай нийлэх нь бий. Тэр нь ч бас ховордсоор авай...

Байгаль эхээ хайрлах хүмүүний хайр ширгэсээр байх дор, ус гол ч бас ширгэж хатахын цондонд өртөх амуй. Уртын гол минь миний хайртай гол юм сан. Миний ч төдийгүй голынхны минь хайртай гол юм сан, урсан цэлэлзэх гол нь төдийгүй улаан гол нь юм сан... Уртын гол минь зүүднээсээ сэрж байна. Хаврын урины үзүүр мөсийг нь нимгэлэн долоож, амсхийж унтсан долгис долгисоо сэрээж, Уртын гол минь зүүднээсээ сэрж байна. Эрэг хөвөөнд нь нялх төлийн дуу цангинаж, ойрх цахилдгийн бутанд сүүлчийн цас хяржээ. Нутгийнхан минь ээ, Уртын гол зүүднээсээ сэрж байна. Гол ус минь ширгэж тасраагүй цагт бидний амь ч бас үргэлжийн мөнхөд билээ...

Д.Нямаа

1. Үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- | | |
|------------|---|
| 1. сэмрэх | a. амарлингуй, дөлгөөн |
| 2. шуудрах | b. нялх хүүхдийн өмсөх жижигхэн гутал |
| 3. усгал | c. торго бөс зэрэг юм элж, ширхэг алдран цуврах |
| 4. бойтог | d. тавилан, ёр бэлгэдэл |
| 5. цондон | e. ажил үйл болон аян явдалд бэлэн болж цэгцрэх |

- | | | |
|-----------------------|-----------------------|-----------------------|
| A. 1с, 2е, 3а, 4b, 5d | B. 1е, 2с, 3а, 4b, 5d | C. 1с, 2е, 3d, 4b, 5а |
| D. 1а, 2d, 3с, 4b, 5е | E. 1b, 2d, 3а, 4с, 5е | |

2. Уртын голын урсгал арвин байсныг илтгэх баримтыг олоорой.

- A. Эрэг хөвөөгөөр нь айл хотол зусаж найрлан, айраг цагаа дэлгэрч, адуу мал цуван, хүн зоны магнай тэнийдэг байсан.
- B. Бороо хуртай үед хүн амьтны хөл хорьж, хэд хоногоор саатуулан үерлэх нь ч энүүхэнд сэн.
- C. Овоо толгойн хаяагаар шуугин өнгөрч, Талын улааны бэлээр шуударч, Хөх бүрдийн нуурт нийлдэг байсан.
- D. Эрэг хөвөөнд нь нялх төлийн дуу цангинаж, ойрх цахилдгийн бутанд сүүлчийн цас хяржээ.
- E. Мөсөн хучлага нь захаасаа сэмэрч, хэрээс, хэгдэс үүсэж, элдэв төрлийн хээ хуарыг урлах ажгуу.

3. Байгаль эхээ хайрлах хүмүүний хайр ширгэсээр байгаагийн үр дагаврыг зөв тодорхойлсон хэсгийг олно уу.

- A. Хаврын урины үзүүр мөсийг нь нимгэлэн долоож, Уртын гол сэрж байна.
- B. Уртын голын урсгал нь саарч, аян холын зам нь богиноссон.
- C. Уртын гол аян замын холд товолзонхон долгилсон.
- D. Уртын гол минь ширгэж, тасраагүй.
- E. Мөсөн хучлага нь захаасаа сэмэрч, хэрээс, хэгдэс үүссэн.

4. Эхийн сэдвийг олоорой.

- A. Уртын голын өнгө үзэсгэлэнгийн тухай
- B. Гол ус багасаж байгаа тухай
- C. Хүний байгальд үзүүлэх хор хөнөөлийн тухай
- D. Гол усаа хайрлан хамгаалах тухай
- E. Уртын голын урсгал арвин болсон тухай

5. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэр нь аль вэ?

- A. Байгаль эхээ хайрлах хүмүүний хайр ширгэсээр байх дор, ус гол ч бас ширгэж хатахын цондонд өртөх амуй.
- B. Гол ус минь ширгэж тасраагүй цагт бидний амь ч бас үргэлжийн мөнхөд билээ...
- C. Нутгийнхан минь ээ, Уртын гол зүүднээсээ сэрж байна.
- D. Уртын гол эрт цагийн явдлаа зүүдэндээ нэг бүрчлэн үзэн баясдаг ч сэрээд уй гунигт автанхан бүүдийх нь он онд.
- E. Жил бүр ирж зусдаг хоёр улаан ангир нь санан ганганасаар нэг л өглөө жигүүр амраан мандалд нь буудаг билээ.

6. Зохиогчийн ямар хандлага, өнгө аяс илэрч байна вэ?

“Нутгийнхан минь ээ, Уртын гол зүүднээсээ сэрж байна. Гол ус минь ширгэж тасраагүй цагт бидний амь ч бас үргэлжийн мөнхөд билээ ...”

- | | | |
|--------------------|------------------------|--------------------|
| A. бишрэн магтсан | B. сануулан захирсан | C. баярлаж хөөрсөн |
| D. уриалан дуудсан | E. харуусаж халагласан | |

7. Эхийн онцолсон хэсгийн хэв маягийг тодорхойлоорой.
- Уртын голын онцлогийг тоочиж, дүгнэн бичсэн учир тайлбарламж, эргэцүүлэмж хосолсон хэв маяг.
 - Уртын голын тухай мэдээлэл өгөх зорилгоор тоочсон тул тайлбарламж.
 - Уртын голын тухай нэг сэдэвт нэгтгэн, учир зүйн дэс дараатай өгүүлсэн тул хүүрнэмж.
 - Уртын голын тухай тайлбарлан таниулахдаа оюун дүгнэлтэд тулгуурласан тул эргэцүүлэмж.
 - Уртын голын гадаад шинжийг нэгэн орон зай, нэгэн цаг хугацааны дотор дүрсэлсэн учир тоочимж.
8. “Уртын гол эрт цагийн явдлаа зүүдэндээ нэг бүрчлэн үзэн баясдаг ч сэрээд уй гунигт автанхан бүүдийх нь он онд” гэсэн хэсгийн амьдчилах ур маягийн үүргийг тодорхойлно уу.
- Уртын гол өвлийн улиралд тэлж хөлдөөд, зуны цагт бүүдийн урсдаг гэсэн санааг урнаар үзүүлсэн.
 - Өвөлдөө хөлддөг, зундаа гэсдэг учраас гол бол амьд юм гэсэн санааг уран яруугаар илэрхийлсэн.
 - Уртын голын урсгал нь татарсаар ширгэж ч магадгүйг үзүүлсэн.
 - Уртын голын гуниг он онд үргэлжилсээр байгаа гэсэн санааг илтгэсэн.
 - Уртын гол урьд цагт урсгал сайтай байсан гэсэн санааг илэрхийлсэн.
9. “магнай тэнийх” гэсэн хэлцийн эсрэг утгатайг нь сонгоорой.
- | | | |
|-------------------|-----------------------|--------------|
| A. магнай хагарах | B. толгойгоо унжуулах | C. хөл алдах |
| D. наран мандах | E. гуяа алгадах | |
10. “Урсгал нь саарч, аян холын зам богиноссон нь юуны учир юм бол?” гэсэн өгүүлбэрийг тонгоргож хувиргасан нь аль вэ?
- Аян холын зам богиноссон нь юуны учир юм бол?
 - Урсгал нь татарч, аян холын зам богиноссон нь юуны учир юм бол?
 - Уртын голын урсгал нь саарч, аян холын зам богиноссон нь юуны учир юм бол?
 - Юуны учир урсгал нь саарч, аян холын зам нь богиноссон юм бол?
 - Урсгал нь саараад, аян холын зам богиноссон нь юуны учир юм бол?
11. Онцолсон үгийг ойролцоо утгатай үгээр солин найруулбал аль үг нь оновчтой вэ?
“**Бороо** элбэгтэй зунд бол Дунд булагийн устай нийлэх нь бий”
- | | | | | |
|-----------|----------|--------|-----------|---------|
| A. мөндөр | B. аадар | C. хур | D. шүүдэр | E. чийг |
|-----------|----------|--------|-----------|---------|
12. “Хүн зоны магнай тэнийж, хүүхэд багачуудын хөөрцөглөн тоглохыг усгал мандалдаа хэчнээн удаа **тольдсон** гэх вэ?” - Онцолсон үгийг ерийн найруулгаар бичсэн нь аль вэ?
- | | | | | |
|----------|-----------|-----------|-----------|---------|
| A. харах | B. ширтэх | C. мэлрэх | D. гөлрөх | E. ажих |
|----------|-----------|-----------|-----------|---------|
13. “Тун удахгүй л хаврын дуугаа дуулан**хан**, мэлтэлзэн**хэн** мэлмэрнэ дээ” - Онцолсон бүтээврийн баймж утгыг тодорхойлоорой.
- | | |
|---------------------------|--------------------------|
| A. сэтгэлийн аяс илтгэх | B. жишин адилтгах |
| C. эс тоомсорлон адилтгах | D. тааварлан барагцаалах |
| E. төсөөлөн барагцаалах | |
14. “**Мөсөн доор** нь жирвэлзэн сэрэх урсгал хүүхдийн бойтгийн хонх шиг жингэнэн хоржигноно”- Өгүүлбэрт онцолсон гишүүний утга, үүргийг тодорхойлно уу.
- “бойтгийн” гэсэн жинхэнэ нэрийг шалтгааны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 - “урсгал” гэсэн жинхэнэ нэрийг зорилгын утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 - “жирвэлзэх” гэсэн үйл үгийг зорилгын утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 - “хоржигнох” гэсэн үйл үгийг цагийн утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 - “сэрэх” гэсэн үйл үгийг орны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.

15. Үйлийн тодотгон холбохын байнга давтагдах одоо цагийн нөхцөлөөр хувилсан үгийг олоорой.
 А. шуударсан В. өнгөрч С. нийлдэг D. очсоор Е. урсана
16. “Тэр нь ч бас ховордсоор авай...” гэсэн өгүүлбэрт цуваа цэг хэрэглэсний учир юу вэ?
 А. Мэгдэж түгдэрсэн буюу ээрч түдгэлзсэн газарт цуваа цэгийг тавина.
 В. Үг, өгүүлбэр төгссөн боловч зохиогч санаагаа бүрэн гаргаж чадаагүй дутуу орхисон гэж үзвэл цуваа цэгийг тавина.
 С. Өгүүлбэр төгсөөгүй буюу өгүүлбэрийн дунд хэлэлгүй орхисон үгийн оронд цуваа цэгийг тавина.
 D. Эш татсан зүйлд энд тэндээс орхисон бол тэр орхисон газрыг цуваа цэг тавьж тэмдэглэнэ.
 Е. Үргэлжилсэн зохиолын том бүлэг, их хэсгийг орхисныг үзүүлэх гэвэл цуваа цэг тавина.
17. Төрөл бус утгат үгийг олоорой.
 А. гараа В. гарц С. гарам D. гараг Е. гарлага
18. Албан бичгийн найруулгад тохирох үгийг сонгоно уу.
 А. хөл хүнд В. жирэмсэн С. бие давхар
 D. их гэдэстэй Е. гэдсэндээ хүүхэдтэй
19. Нутгийн аялгууны үгийг халх аялгуунд зөв буулгасан нь аль вэ?
 Түрэнхэн тоонтотнай хаанаб?
 А. Төрсөн тоонтотнай хаана вэ? В. Түрүүхэн тоонот хаана вэ?
 С. Түрхэн тоонот хаана вэ? D. Төрсөн нутаг хаана вэ?
 Е. Тоонот хаанав?
20. Хамжиж угсарсан нийлмэл үгийг сонгоно уу.
 А. Үхэр чулуу В. Айраг цагаа С. Уртын гол
 D. Бойтгийн хонх Е. Цагаан өнгө
21. Утгыг зөв харгалзуулсныг олно уу.
 1. Буурь а. агтлаагүй эр тэмээ
 2. Буйр b. суурь ором
 3. Буур с. нуурын нэр
 А. 1с, 2а, 3b В. 1а, 2с, 3b С. 1b, 2с, 3а
 D. 1а, 2b, 3с Е. 1b, 2а, 3с
22. Үгийн үндэс (язгуур) -д залгавар залгахад зөөлний тэмдэг “и” болсон үгсийг олоорой.
 А. охиноос, говиор, ашиг В. түшиг, ажил, начин
 С. болиод, давхидаг, сарниж D. горхиор, тархины, хурим
 Е. ханилж, амилдаг, гуниг
23. “шан + на + чих + аарай” гэсэн бүтээврийн нийлцийг зөв бичсэн нь аль вэ?
 А. шанначихаарай В. шанначхаарай С. шагначихаарай
 D. шагначхаарай Е. шаганчихаарай
24. “Америкаас хөлөөр нь авчирсан машин зарна” гэсэн өгүүлбэрийн найруулгын алдааг зөв зассаныг олоорой.
 А. Америкаас унаж ирсэн машин зарна.
 В. Америкаас өөрөөр нь авчирсан машин зарна.
 С. Америкаас дугуйгаар нь авчирсан машин зарна.
 D. Америкаас өөрөө ирсэн машин зарна.
 Е. Америкаас хөлөөрөө ирсэн машин зарна.

25. Э.Хэмингуэй “Өвгөн тэнгис хоёр” зохиол дахь жаал хүүгийн хэлсэн үгээс зан төрхийг нь тодорхойлно уу.
 “- Сантьяго, би одоо тантай дахиад тэнгист гарч чадна... гэж жаал хүү хэлэв. Өвгөн, загас барихыг хүүд зааж өгсөн тул хүү түүнд хайртай билээ.
 - Үгүй, чи ганзага нийлэх завь олсон болохоороо тэндээ бай гэж өвгөн хэлэв.
 - Таныг наян долоон өдөр тэнгист гараад юу ч бариагүй ирэхэд дараа нь хоёулаа гараад гурван долоо хоног өдөр бүр том загастай ирж байснаа санаж байна уу?
 - Санахгүй яах вэ. Чи намайг загас барьж чадахгүй гэж бодсондоо орхиод яваагүй л дээ. Би үүнийг чинь мэдэж байна гэж өвгөн хэлэв”
 А. ажилч хичээнгүй В. алиа хошин С. өрөвч зөөлөн
 D. нийтэч, нөхөрсөг E. бялдууч, их зантай
26. Д.Намдаг “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэгийн дараах хэсэгт ямар хам сэдэв хөндөгдөж байна вэ?
 “1939 оны намар говь нутагт суудлын ногоон машинтай цэргийн нэг дарга, Нямаа өвгөн гэгчийнхийг эрэн сурсаар очив. Тэрээр Халх голын байлдаанд байлдсан нэг бага даргын тухай яваа боловч очсон тэр айлдаа баяр баясгаланг өгч чадсангүй...”
 А. улс төрийн В. түүхийн С. соёлын D. нийгмийн E. шашны
27. А.П.Чехов “Хамелеон” өгүүллэгийн дараах хэсгээс дотоод орчныг тодорхойлно уу.
 “Очиж үзвэл, пингийн үүдний дэргэд өнөөх хүн баруун гараа дээш өргөж, цустай хуруугаа олонд үзүүлэн байв. Түүний хагас согтуу царайд хорсол илэрхий.
 ...Очумелов түүнийг ажиглавал алтны дархан Хрюкин мөн аж. Тэдний дунд будилаан гаргасан цагаан гөлгөн нохой бүх бие нь дагжин чичирч, цогнойн сууна. Түүний нулимст нүдэнд айсан шинж илэрхий”
 А. түгшүүр шаналгаатай орчин
 В. харамсал, харуусал дүүрэн орчин
 С. уур хилэн хийгээд уйтгар гуниг бүхий орчин
 D. уур хилэн хийгээд айдас хүйдэс бүхий орчин
 E. айдас хүйдэс хийгээд уйтгар гуниг бүхий орчин
28. С.Дашдооров “Бууж мордох хорвоо” зохиолд Төгөө, ямар учраас Ангаа өвгөнийг эцсийн замд үдэхэд нь халуун хошуутай мал байлгах гэсэн бэ?
 А. Үлдэж байгаа улсыг нь бага ч болов баярлуулах гэсэн.
 В. Хөөрхий өвгөнийг баярлуулах гээд чадаагүй.
 С. Өвгөний замд хонь мал байлгая гэж бодсон.
 D. Хүн өөрсдөө мэдэхгүйгээс биш, бие биедээ өртэй.
 E. Сүүлчийн удаа өвгөнийг баярлуулах гэсэн.
29. С.Эрдэнийн “Өвгөн шувуу” өгүүллэгт “...Хэчнээн сайхан салж болмооргүй ертөнц боловч Гээгтийн дуулдаг өвгөн шувуу шиг буцах цаг болжээ... Жам юм хойно. Ямар манай монголын удам тасрахаар биш! Та нар минь тэгээд үр ач өнөр өтгөн жаргаж дэгжиж яваарай” гээд үүр шөнө хагацахын алдад насан өөд болсон өвгөн хэн бэ?
 А. Гэээгт В. Жамц С. Жав D. Дорлиг E. Должин
30. Б.Явуухулан “Нүүдэлчний намар” шүлэгт “найгаа л, хийсээ л, суугаа л, буцаа л, буугаа л” хэмээн “л” авиа хэрэглэсний учир юу вэ?
 А. Намар цагт хүний сэтгэл тогтворгүй, хөнгөн байдгийг илэрхийлэхийн тулд “-л” авиа хэрэглэсэн.
 В. Буцаж буй намар цаг, хүний сэтгэлийг дэнсэлгэсэн уйтай байдлыг илэрхийлэхийн тулд нэгэн хэмээр “-л” авиа хэрэглэсэн.
 С. “л” авиа нь сул, дуутай, хэлний урдуурх, хамрын биш, чичрэх гийгүүлэгч тул юмс үзэгдлийн хөдөлгөөнийг илтгэдэг.

- D. Намар цагийн байгалийн өнгийг зураглахад “л” авиа тохиромжтой.
- E. Шүлгийг яруу сонсголонтой болгохын тулд “л” авиагаар сүүл холбосон.

31. Уншаад, зөв хөрвүүлснийг олоорой.

Өгөгжөөр үгсийг хөрвүүлж
 үгсийг хөрвүүлж үгсийг
 үгсийг хөрвүүлж үгсийг
 үгсийг хөрвүүлж үгсийг

- A. Бардам мунхаг хүнээр эрдэм үл гармуй. Баясгалан мэргэдээр уршиг үл гармуй.
- B. Бардам мунхаг хүн эрдэм үл гаргамуй. Баясгалан мэргэдээс уршиг үл гармуй.
- C. Бардам муу хүнээс эрдэм үл гармуй. Баясгалант мэргэдээс уршиг үл гармуй.
- D. Бардам мунхаг хүнээс эрдэм үл гармуй. Баясгалан мэргэдээс уршиг үл гармуй.
- E. Бардам мунхаг хүнээс эрдэм үл гармуй. Баясгалант мэргэдийн уршиг үл гармуй.

32. Уншаад, тохирох тайлбарыг сонгоорой.

Өгөгжөөр үгсийг
 үгсийг хөрвүүлж үгсийг

- A. давхар гарлага гарах
- B. бага зэргийн олз олох
- C. сүр бадруулан хэтрүүлж ярих
- D. тэмээ, ямаа хариулах
- E. бие биеэ сайн мэдэх

33. “дуучин улс” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

- A. Өгөгжөөр үгсийг
- B. Өгөгжөөр үгсийг
- C. Өгөгжөөр үгсийг
- D. Өгөгжөөр үгсийг
- E. Өгөгжөөр үгсийг

34. Галигийг зөв бичсэн хэсгийг сонгоно уу. Байнгали эхэ-бэн хайралаху хүмүн-ү хайир-а.

- A. Өгөгжөөр үгсийг
- B. Өгөгжөөр үгсийг
- C. Өгөгжөөр үгсийг
- D. Өгөгжөөр үгсийг
- E. Өгөгжөөр үгсийг

35. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- | | | | | |
|--------|--------|--------|--------|--------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠨᠢᠭᠡᠨᠢ | ᠨᠢᠭᠡᠨᠢ | ᠨᠢᠭᠡᠨᠢ | ᠨᠢᠭᠡᠨᠢ | ᠨᠢᠭᠡᠨᠢ |

36. “зүүднээсээ” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

- | | | | | |
|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠵᠡᠭᠦᠳᠦᠨᠡᠭᠡᠰᠡᠭᠡ | ᠵᠡᠭᠦᠳᠦᠨᠡᠭᠡᠰᠡᠭᠡ | ᠵᠡᠭᠦᠳᠦᠨᠡᠭᠡᠰᠡᠭᠡ | ᠵᠡᠭᠦᠳᠦᠨᠡᠭᠡᠰᠡᠭᠡ | ᠵᠡᠭᠦᠳᠦᠨᠡᠭᠡᠰᠡᠭᠡ |

37. Байдлын дагавартай үгийг олоорой.

- | | | | | |
|--------|--------|--------|--------|--------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠨᠢᠭᠡᠨᠢ | ᠨᠢᠭᠡᠨᠢ | ᠨᠢᠭᠡᠨᠢ | ᠨᠢᠭᠡᠨᠢ | ᠨᠢᠭᠡᠨᠢ |

38. “яв-” гэсэн үгийг цагаар төгсгөх нөхцөлөөр хувилгахад аль нөхцөлийг бичих вэ?

- | | | | | |
|-------|-------|-------|-------|-------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠶ᠋ᠠᠪᠢ | ᠶ᠋ᠠᠪᠢ | ᠶ᠋ᠠᠪᠢ | ᠶ᠋ᠠᠪᠢ | ᠶ᠋ᠠᠪᠢ |

39. “амар мэнд, амар хялбар”-ыг утга ялгасан хэсгийг олоорой.

- | | | | | |
|------------------------|------------------------|------------------------|------------------------|------------------------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠠᠮᠠᠷᠢᠮᠡᠨᠳᠤᠨᠠᠮᠠᠷᠬᠢᠯᠢᠪᠠᠷ | ᠠᠮᠠᠷᠢᠮᠡᠨᠳᠤᠨᠠᠮᠠᠷᠬᠢᠯᠢᠪᠠᠷ | ᠠᠮᠠᠷᠢᠮᠡᠨᠳᠤᠨᠠᠮᠠᠷᠬᠢᠯᠢᠪᠠᠷ | ᠠᠮᠠᠷᠢᠮᠡᠨᠳᠤᠨᠠᠮᠠᠷᠬᠢᠯᠢᠪᠠᠷ | ᠠᠮᠠᠷᠢᠮᠡᠨᠳᠤᠨᠠᠮᠠᠷᠬᠢᠯᠢᠪᠠᠷ |

40. “философи” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

- | | | | | |
|------------|------------|------------|------------|------------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠮᠢᠯᠠᠰᠤᠰᠤᠮᠢ | ᠮᠢᠯᠠᠰᠤᠰᠤᠮᠢ | ᠮᠢᠯᠠᠰᠤᠰᠤᠮᠢ | ᠮᠢᠯᠠᠰᠤᠰᠤᠮᠢ | ᠮᠢᠯᠠᠰᠤᠰᠤᠮᠢ |

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг будаарай.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр нэг оноотой.

2.1. Зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөрд зөвхөн нэг хариултыг будаарай)

- | | |
|---------------------------------------|---------------------|
| a. Эрэг хөвөөгөөр нь айл хотол зусна. | 1. цөм өгүүлбэр |
| b. Уртын гол зүүдэлнэ. | 2. цөм бус өгүүлбэр |
| c. Адуу мал цувна. | |
| d. Сүүлчийн цас хяржээ. | |
| e. Ангир жигүүр амраана. | |





2.2. Монголын Нууц Товчоо дахь жишээг дүрслэх ур маягтай нь зөв харгалзуулна уу.

- | | |
|---|--------------|
| a. Эмээлээ тохуул
Үүдээ сөхүүл | 1. зүйрлэл |
| b. Хар хэрээ мэт
Хамаг юмыг харамлаж | 2. багасгал |
| c. Өдөр үзэх нүд
Шөнө сонсох чих болгох | 3. адилтгал |
| d. Ган төмөр зүрхтэй
Гадас цүүцэн хошуутай | 4. тойруулал |
| e. Уужим их газрыг довын төдий байхад
Усан их мөрнийг горхины төдий байхад | 5. төлөөлөл |

2.3. Зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөрд зөвхөн нэг хариултыг будаарай)

- | | |
|-------------------|---|
| a. үлгэр + ээр | 1. Балархай эгшиг үүрэггүй тул гээнэ. |
| b. дагавар + ыг | 2. Ялгах үүрэгтэй тул балархай эгшгийг гээхгүй. |
| c. гачигдал + аас | 3. Эгшигжүүлэх үүрэгтэй тул балархай эгшгийг гээхгүй. |
| d. мэдсэн + ээр | |
| e. үнэн + ээс | |

2.4. Үгсийг тохирох утгатай нь харгалзуулна уу. (a, b, c, d, e мөрд зөвхөн нэг хариултыг будаарай)

- | | | | | |
|--------------|---|---|---|---|
| | 1. | 2. | 3. | 4. |
| a. тал нутаг | | | | |
| b. дал мөр |  |  |  |  |
| c. далын тоо | | | | |
| d. арьс тэл- | | | | |
| e. дэл сүүл | | | | |